

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ

Энэ хууль бие даасан Иргэний нисэхийн ерөнхий газар байгуулах, тус улсад иргэний нисэхийн ажиллагааг зохицуулах, дэмжих, түүний аюулгүй ажиллагаанд тус дөхөм үзүүлэх, эдгээртэй холбоотой бусад зорилготой болно.

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

101. Товчилсон нэр

Энэ хуулиас ишлэл авахдаа 2001 оны Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль гэж нэрлэж болно.

102. Нэр томъёо

Монгол Улс. Энэ хуульд хэрэглэсэн Монгол Улс гэсэн нэр томъёо нь тус улсын нутаг дэвсгэрийг хэлэх бөгөөд үүнд түүний агаарын зай хамаарна.

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

Aerial work. Агаарын хөлгийг хөдөө аж ахуй, барилга, зураг авалт, зураглалт хийх, эргүүл, авран туслах, агаарын зар сурталчилгаа хийх зэрэг тусгай үйлчилгээнд ашиглах.

Нисэх буудал. Бүхэлдээ буюу зарим хэсэг нь агаарын хөлгийн ирэх, нисэх, газар дээр гүйхэд ашиглах зориулалт бүхий нисэх онгоцны буудал, газар буюу усан дээр тогтоосон талбай (үүнд аливаа барилга байгууламж, тоноглол, төхөөрөмж).

Агаарын хөлөг. Газрын гадаргуунаас үүссэн агаарын урсгалын нөлөөллөөс бус өөрөө агаартай харилцан үйлчлэн дэмжлэг үүсгэж авч чадах аливаа машин. Энэ хууль, түүний дагуу гаргасан дүрэм, журамд хэрэглэсэн утгаар энэ нь зөвхөн иргэний агаарын хөлөгт хамаарч харин төрийн буюу нийтийн өмчийн агаарын хөлөгт хамаарахгүй.

Агаарын хөлгийн хөдөлгүүр. Агаарын хөлгийг хөдөлгөхөд зориулагдсан аливаа хөдөлгүүр болон хөдөлгүүрээс бусад аливаа нэмэлт төхөөрөмж, хэрэгсэл.

Агаарын хөлгийг авч зугатах. Монгол Улсын харьяалалд байгаа агаарын хөлгийг хүч хэрэглэх буюу хууль бус зорилгоор мэдэлдээ авч булаан авах буюу булаан авахыг завдах.

Нисэхийн ажилтан.

хөлгийн дарга, нисгэгч, механик буюу агаарын хөлгийг underway байхад түүнийг жолоодож байгаа аливаа этгээд;

агаарын хөлгийн үзлэг, засвар үйлчилгээ, их засвар хариуцсан аливаа этгээд, мөн агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, хэрэгслийн засварыг хариуцсан аливаа этгээд;

нислэгийн үйл ажиллагааны мэргэжилтнээр ажилладаг аливаа хувь хүн.

Агаарын навигацийн тоноглол. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийн зориулалтаар ашигладаг, ашиглаж болох буюу тийнхүү ашиглах зориулалттай аливаа тоноглол, үүнд нисэх буудал, буух талбай, гэрэлтүүлэг, цаг агаарын мэдээ дамжуулах, дохио өгөх, радио-удирдлагатай ээрж олох болон цахилгаан соронзон холбооны аливаа аппарат буюу тоног төхөөрөмж, түүнчлэн агаарын хөлгийг агаарт нисч байхад буюу буух, хөөрөхөд удирдах, хянахад эдгээртэй төстэй зориулалт бүхий аливаа бусад төхөөрөмж, механизм.

Нисэхийн тээвэрлэгч. Шууд буюу шууд бусаар эсхүл түрээс болон бусад тохиролцооны үндсэн дээр дотоодын комерийн агаарын тээвэр буюу олон улсын агаарын тээвэр эрхэлдэг аливаа байгууллага.

Нисэхийн operatorын гэрчилгээ. Нисэхийн тээвэрлэгчид комерийн агаарын тээврийн тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрсөн гэрчилгээ.

Чикагогийн конвенцийн хавсралтууд. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас гаргасан, иргэний нисэхэд хамаарах Жишиг, зөвлөмж бүхий баримт бичгүүд.

Хэрэгсэл. Агаарын хөлгөөр нислэг үйлдэж байх үед түүний навигаци, operation буюу хянахад хэрэглэдэг, хэрэглэх боломжтой буюу хэрэглэх гэж байгаа багаж, тоног төхөөрөмж, аппарат, эд анги, accessories (үүнд шүхэр, холбооны хэрэгсэл болон агаарын хөлөгт нислэгийн үед суурилуулсан буюу залгасан аливаа бусад механизм) байх бөгөөд эдгээр нь агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнсний хэсэг/эд анги биш байна.

Чикагогийн конвенци. Иргэний нисэхийн гэрээний олон улсын үндэс.

Комерийн агаарын тээвэр. Цалин буюу хөлсөөр зорчигч, ачаа, шууданг тээвэрлэх агаарын хөлгийн ажиллагаа.

Монгол Улсын иргэн. Энэ нэр томъёо дор дурдсаны аль нэгийг хэлнэ:

Монгол Улсын иргэн хувь хүн;

Гишүүн бүр нь Монгол Улсын иргэн нөхөрлөл;

Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан корпораци буюу нийгэмлэг.

Иргэний агаарын хөлөг. Төрийн буюу нийтийн өмчийнхээс бусад агаарын хөлөг.

Иргэний нисэх. Аливаа иргэний агаарын хөлгийн нисэхийн ерөнхий ажиллагаа, aerial work буюу комерийн агаарын тээврийн зорилгоор ажиллуулах.

Багийн гишүүн. Агаарын хөлөгт нислэгийн үед гүйцэтгэх үүрэг хүлээсэн хүн.

Аюултай зүйл. Агаараар тээвэрлэхэд хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, хөрөнгөд үлэмж аюул учруулах зүйл буюу бодис.

Ерөнхий захирал. Энэ хуулийн дагуу томилогдсон Иргэний нисэхийн Ерөнхий захирал.

Гадаадын нисэхийн тээвэрлэгч. Шууд буюу шууд бусаар эсхүл түрээс болон бусад тохиролцооны үндсэн дээр Монгол Улсын хилийн дотор буюу түүний агаарын зайд хуваарьт буюу захиалгат нислэгийн журмаар комерийн агаарын тээвэр эрхлэх Монголын нисэхийн тээвэрлэгч аас бусад нисэхийн тээвэрлэгч.

Ерөнхий нисэхийн ажиллагаа. Комерийн агаарын тээвэр, aerial work ажиллагаанаас бусад.

ОУНБ (ICAO). Олон улсын иргэний нисэхийн байгууллагын товчлол.

Олон улсын комерийн агаарын тээвэр. Агаарын хөлгөөр хүн буюу эд хөрөнгийг цалин, хөлсөөр тээвэрлэх буюу хоёр, түүнээс дээш улсын хооронд шуудан тээвэрлэх.

Сайд. Иргэний нисэхийг хариуцсан сайд.

Нислэг үйлдэж болох агаарын зай. Энэ хуулийн дагуу батлагдсан журмаар тогтоосон нислэгийн доод талын өндөр; үүнд агаарын хөлгийн хөөрөх, буухад аюулгүй байдлыг хангахад хүрэлцэх агаарын зай.

Агаарын хөлгийг navigation. Агаарын хөлгийг жолоодохыг багтаасан үйлдэл.

Тээвэрлэгч. Агаарын хөлгийн ажиллагаа эрхэлдэг хүн, байгууллага, үйлдвэрийн газар. Агаарын хөлгийг өмчлөгч, түрээслэгч буюу бусдаар энэ хуульд хэрэглэсэн утгаар operation эрхэлдэг буюу эрхлэхийг санал болгодог аливаа этгээд.

Этгээд. Аливаа хувь хүн, нөхөрлөл, корпорац, компани, нийгэмлэг, хувьцаат компани, үүнд итгэмжлэгдэгч, эрх хүлээн авагч, буюу эдгээр нэгжийн бусад адил төстэй төлөөлөгч.

Сэнс. Сэнсний бүх хэсэг, нэмэлт төхөөрөмж, хэрэгсэл.

Нийтийн агаарын хөлөг. Зөвхөн Засгийн газрын үйлчилгээнд ашигладаг агаарын хөлөг, үүнд олон улсын комерийн агаарын тээврийн үйлгөлтөд багтдаг үйл ажилаагаа эрхэлдэг төрийн өмчийн агаарын хөлөг хамаарахгүй.

Сэлбэг хэрэгсэл. Хөдөлгүүр, сэнснээс бусад агаарын хөлгийн болон аливаа хэсэг, нэмэлт төхөөрөмж, хэрэгсэл.

Монгол Улсын агаарын хөлгийн тусгай харьяалалд дараахь зүйл хамаарна:

Монгол Улсын агаарын хөлөг;

Нислэгийн (агаарын хөлгийг ачалсны дараа гаднахь бүх хаалгыг хааснаас хойш газардахын тулд нэг хаалгыг нээх, аваарын буултын үед эрх бүхий байгууллага, албан тушаалтан агаарын хөлөг, түүний доторх зорчигч, хөрөнгийн талаарх хариуцлагыг хүлээж авах хүртэл) үед Монгол Улсын харьяалал дахь аливаа бусад агаарын хөлөг.

Хүчинтэй болгох_Энэ хуулиар Ерөнхий захиралд хариуцуулсан үйлдлийн оронд өөр улсын иргэний нисэхийн удирдах газраас хийсэн үйлдлийг бичгээр зөвшөөрөх.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

201. Ерөнхий газрыг байгуулах

а) Ерөнхий захирлаар удирдуулсан газрыг байгуулах. Үүгээр Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “Ерөнхий газар” гэх)-ыг байгуулав. Газрыг Ерөнхий сайдаас Улсын Их хуралтай зөвшилцөн томилсон Ерөнхий захирал (цаашид “Ерөнхий захирал” гэх) удирдах бөгөөд Монгол Улс дахь иргэний нисэх болон энэ хуулийн биелэлтийг хариуцна. Ерөнхий захирлыг 4-өөс доошгүй жилийн хугацаагаар томилж Ерөнхий сайд, Парламентын гарын үсэг бүхий тогтоолоос бусдаар чөлөөлж болохгүй.

б) Ерөнхий захирлын үүрэг. Ерөнхий захирал нь Ерөнхий газар бүх эрхээ хэрэгжүүлж үүргээ гүйцэтгэх явдлыг хариуцаж түүний бүх ажиллагчид, үйл ажиллагааг удирдана.

202. ЕРӨНХИЙ ГАЗРЫН БОДЛОГЫН ТОДОРХОЙЛОЛТ

Энэ хуулийн дагуу эрхээ хэрэгжүүлж үүргээ гүйцэтгэхдээ Ерөнхий захирал нь дараахь зүйлийг нийтийн сонирхолд нийцсэн гэж харгалзан үзнэ:

Иргэний нисэх дахь аюулгүй ажиллагааг дэмжих, хөгжүүлэх;

Иргэний нисэхийг аюулгүй ажиллагааг аль болохоор хөгжүүлэн дэмжих байдлаар зохицуулах.

203. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛД ТАВИХ ШААРДЛАГА

г) Ерөнхий захирлыг томилоход энэ хуульд заасан эрх, үүргийг үр нөлөөтэй гүйцэтгэхэд тохирох эсэхийг шалгуур болгоно.

Ерөнхий захирал нь энэ албан тушаалд томилогдох үедээ удирдлагын салбарт үлэмж буюу нисэхтэй шууд холбоотой салбарт техникийн дадлага туршлагатай байна.

Ерөнхий захирал аэронавтикийн аль нэг үйлдвэрийн газрын хувьцаанд эрх эзэмших, бусад аж ахуйн нэгж, мэргэжил, ажил эрхэлж болохгүй.

204. МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛЛАГЧИД

Ерөнхий захирал энэ хуулийг биелүүлэхэд шаардлагатай мэргэжилтэн, ажиллагчид, зөвлөх, хуулийн зөвлөгч, төлөөлөгч нарыг шилж сонгох, томилох, ажиллуулах, тэдний эрх, үүргийг тодорхойлж болно. Ерөнхий газрын мэргэжилтэн, ажиллагчид, зөвлөх, хуулийн зөвлөгч, төлөөлөгч нь аэронавтикийн аль нэг үйлдвэрийн газрын хувьцаанд эрх эзэмшиж болохгүй.

ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ

301. БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

Ерөнхий захирал бусад байгууллагын үйлчилгээ, тоног төхөөрөмж, ажилтнууд, байгууламжийг тэдний зөвшөөрлөөр төбөртэйгээр ашиглах, түүнчлэн Ерөнхий газрын үйлчилгээ, тоног төхөөрөмж, байгууламжийг байгуулах, бий болгох талаар тэдгээртэй хамтран ажиллах бүрэн эрхтэй.

302. ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

Ерөнхий захирал тохиромжтой тохиолдолд

Монгол Улсын нэрийн өмнөөс аливаа бэлэг, үл хөдлөх болон хувийн хөрөнгийг мөнгө, бусад хэлбэрээр, мөн үйлчилгээний хандив хүлээж авах;

Худалдан авах, түрээслэх буюу бусад хэлбэрээр үл хөдлөх болон хувийн хөрөнгө, түүний талаарх эрх, үүнд тус улсын өмчилж эзэмшиж байгаа нисэхийн навигацийн тоноглолын хувьд сервитутын үндсэн дээр зэргэлдээх болон түүнтэй холбоотойгоор шаардлагатай агаарын зайд эдлэх.

303. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Ерөнхий захирал Монгол Улсын холбогдох хуульд нийцүүлэн энэ хуульд заасан эрх, үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд хувь хүн, хувийн, нийтийн буюу төрийн байгууллагатай гэрээ байгуулах буюу бусдаар тэднээр үйлчлүүлэх явдлыг зохион байгуулж болно.

304. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

Ерөнхий захирал, тус улсын Засгийн газрын холбогдох байгууллагаар дамжуулан гадаад улсын засгийн газруудтай иргэний нисэхийн холбогдолтой мэдээлэл солилцох бүрэн эрхтэй.

305. ЧИГ ҮҮРЭГ ШИЛЖҮҮЛЭХ

д) ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛЛАГЧИД, ЗАХИРГААНЫ НЭГЖИД ШИЛЖҮҮЛЭХ. Ерөнхий захирал журам, зааварт нийцүүлэн өөрийн харьяаллын аль ч мэргэжилтэн, ажиллагч, захиргааны нэгжид энэ хуульд заасан аль ч эрх, үүргээ шилжүүлж болно.

ХУВЬ ХҮНД ШИЛЖҮҮЛЭХ. Ерөнхий захирал, журам, зааварт нийцүүлэн зохих мэргэшил бүхий хувь хүнд энэ хуульд заасан аль ч эрх, үүргээ шилжүүлж болох боловч тийнхүү шилжүүлснээр нисэхийн тээвэрлэгчид, aerial work буюу нисэхийн ерөнхий ажиллагааны тээвэрлэгчид болон засвар үйлчилгээний газрууд өөрсдөө өөрсдийгөө зохицуулахгүй байх явдлыг хангана.

ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ. НИЙТЛЭГ БҮРЭН ЭРХ, ҮҮРЭГ

401. НИЙТЛЭГ ЗААЛТ

е) ЕРӨНХИЙ БҮРЭН ЭРХ. Ерөнхий захирал энэ хуулийн заалтыг биелүүлэх, энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн үйлдэл хийх, шалгалт хийх, энэ хуулийн дагуу түүнд нийцүүлэн тушаал гаргах, өөрчлөх, дүрэм, журам, заавар гаргах, өөрчлөх бүрэн эрхтэй.

ХЭВЛЭН НИЙТЛЭХ. Ерөнхий захирал энэ хуулийн дагуу гаргасан бүх тайлан, тушаал, шийдвэр, дүрэм, журмыг нийтэд мэдээлэх, ашиглахад хамгийн тохиромжтой хэлбэр, байдлаар хэвлэн нийтлэх явдлыг хангана.

НОТЛОХ БАРИМТ. Энэ хуулиар зөвшөөрсөн аливаа хянан хэлэлцэх буюу шинжлэн шалгах ажиллагааг яуулахад Ерөнхий захирал нотлох баримт хүлээж авах, дуудан ирүүлэх, бичгийн тодорхойлолт хүлээж авах бүрэн эрхтэй. Ийм тохиолдолд Ерөнхий захирлын ажиллагааг энэ хуулийн 8-р дэд бүлэгт зааснаар зохицуулна.

402. ТУШААЛ

ж) ТУШААЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА Хойшлуулшгүй тохиолдлоос бусад үед Ерөнхий захирлын бүх тушаал, дүрэм, журам түүний тогтоосон ердийн боломжит

хугацаанд хүчинтэй болох бөгөөд дараагийн тушаал, дүрэм, журам гарах хүртэл, эсхүл тухайн тушаал, дүрэм, журамд заасан хугацаанд хүчинтэй байна.

ХОЙШЛУУЛШГҮЙ ТОХИОЛДОЛ. Ерөнхий захирал, иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үүднээс шуурхай арга хэмжээ шаардсан хойшлуулшгүй байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд гомдлыг үндэслэн эсхүл өөрийн санаачилгаар сонирхогч этгээдээс хариу авахгүйгээр, мэдэгдэл, хянан хэлэлцэх ажиллагаагүйгээр хойшлуулшгүй байдалд шаардлагатай тушаал, дүрэм, журам гаргаж болох бөгөөд түүний үндэслэл болсон асуудлын талаар шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй үүсгэнэ.

ТУШААЛЫГ ТҮР ЗОГСООХ, ӨӨРЧЛӨХ. Ерөнхий захирал энэ тухай урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр тушаалыг түр зогсоох, өөрчлөх бүрэн эрхтэй.

403. ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ ХАМААРАХ НЬ

Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу дүрэм, журам гаргахдаа Ерөнхий захирал Захиргааны хариуцлагын тухай хуулийн заалтыг баримтална.

404. НИЙТЭЭР ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ

Хувь хүн бүр (байгууллагын хувьд түүний аливаа төлөөлөгч, ажиллагчид) Ерөнхий захирал энэ хуулийн дагуу гаргасан тушаал, дүрэм, журам, гэрчилгээний заалтыг тухайн этгээдэд холбогдолтой бол хүчинтэй байх хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

405. ХАМААРАХГҮЙ БАЙХ

з) Ерөнхий захирал, тухайн үйллийг нийтийн эрх ашигт нийцсэн гэж үзвэл энэ хуулийн дагуу гаргасан тушаал, дүрэм, журмыг биелүүлэх шаардлагаас чөлөөлж болно.

Энэ хуулийн а)-д зааснаас бусад тохиолдолд Ерөнхий захирал энэ хуулийн шаардлагыг биелүүлэх явдлаас чөлөөлж болхгүй.

406. ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Ерөнхий захирал Монгол Улсад иргэний нисэхийг аюулгүй ажиллагааг хангахуйцаар хөгжүүлэх явдалд тус дөхөм үзүүлэх бүрэн эрхтэй.

407. АГААРЫН ЗАЙН ХЯНАЛТ, ТОНОГЛОЛ

л) АГААРЫН ЗАЙГ АШИГЛАХ. Ерөнхий захирал Монгол Улсын нислэг үйлдэж болох агаарын зайг ашиглах талаар бодлого боловсруулах, төлөвлөх, тодорхойлох эрхтэй. Ерөнхий захирал нислэг үйлдэж болох агаарын зайг аюулгүйр дүнтэй ашиглах явдлыг хангахад шаардлагатай гэж үзсэн нөхцөл, хязгаарлалтыг дүрэм, журам буюу тушаалаар тогтоох эрхтэй.

БҮРЭН ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ. Ерөнхий захирлын энэ зүйлд заасан бүрэн эрхийг зөвхөн олон улсын гэрээгээр нисэхийн хөд/нислэгийн хөдөлгөөний удирдлага гадаад улсад хариуцуулаагүй агаарын зайд хэрэгжүүлж болно.

408. НИСЭХИЙН НАВИГАЦИЙН ТОНОГЛОЛ

м) Ерөнхий захирал боломжтой хэмжээнд дараахь эрхтэй:

шаардлагатай үед нисэхийн навигацийн тоноглолыг олж авах, байгуулах, сайжруулах;

навигацийн тоноглолыг ажиллуулах, тэдгээрт засвар үйлчилгээ хийх.

409. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ

н) ЕРӨНХИЙ ЗААЛТ. Ерөнхий захирал нисэхийн аюулгүй ажиллагааны сонирхолын үүднээс шаардлагатай гэж үзвэл дараахь нислэгийн хөдөлгөөний дүрэм, журам баталж болно:

агаарын хөлгийн нислэгийн талаар;

газар дээрх хүмүүс, эд хөрөнгийг хамгаалах талаар;

нислэг үйлдэж болох агаарын зайг үр дүнтэй ашиглах талаар, үүнд нислэгийн аюулгүй өндөр, агаарын хөлгүүд хоорондоо, газар, уснаа явагч, зүйл, болон агаардахь зүйлтэй мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх талаар.

ТОНОГЛОЛ, АЖИЛТНУУД. Ерөнхий захирал, нисэхийн аюулгүй ажиллагааны сонирхолын үүднээс нислэгийн хөдөлгөөнийг хамгаалах, зохицуулахад шаардлагатай тоноглол, ажилтнуудаар хангах эрхтэй.

БҮРЭН ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ. Ерөнхий захирлын энэ зүйлд заасан бүрэн эрхийг зөвхөн олон улсын гэрээгээр нислэгийн хөдөлгөөний удирдлагыг гадаад улсад хариуцуулаагүй агаарын зайд хэрэгжүүлж болно.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ, ИРГЭНИЙ ХЭРЭГЦЭЭ. Ерөнхий захирал, энэ хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэх, хуулиар даалгасан үүргээ биелүүлэхдээ үндэсний батлан хамгаалах, комерийн болон ерөнхий нисэхийн шардлага, нислэг үйлдэж болох агаарын зайгаар зорчих нийтийн эрхийг бүрэн харгалзан үзнэ.

410. КОМЕРИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН ААЮУЛГҮЙ БАЙДАЛ

о) ҮЗЛЭГ ХИЙХ. Ерөнхий захирал, комерийн агаарын тээврээр агаарын хөлгийн бүхээгт тээвэрлэх бүх зорчигч, эд хөрөнгийг зэвсэг илрүүлэх ажиллагаа, төхөөрөмжөөр нисэхийн тээвэрлэгч буюу гадаадын тээвэрлэгч

тийнхүү тээвэрлэхээр агаарын хөлөгт ачаалахын өмнө шалгахыг шаардсан боломжит журам тогтооно.

ХҮЧ ХЭРГЭЛЭХ, АГААРЫН ХӨЛӨГ БУЛААХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ. Ерөнхий захирал, комерийн агаарын тээвэр эрхэлдэг агаарын хөлгийн бүхээг дэх хүмүүс, эд хөрөнгийг эрүүгийн шинжтэй хүч хэрэглэх, агаарын хөлгийг булаахаас хамгаалахад шаардлагатай гэж үзсэн бусад ажиллагаа, арга, журмыг тогтоосон дүрэм, журам гаргах эрхтэй.

ҮЗЛЭГ ХИЙХ, СААТУУЛАХ, ЭРЖ ХАЙХ ЖУРАМ. Ерөнхий захирал, зохистой хэмжээнд дотоодын комерийн агаарын тээвэр болон олон улсын комерийн агаарын тээвэрт хүмүүс, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах, тэдгээртэй нисэхийн тээвэрлэгчс, тэдний төлөөлөгч, ажиллагсад зөв боловсон харьцах явдлыг хангахын тулд үзлэг хийх, саатуулах, эрж хайх нэгдсэн журамтай байхыг шаардана.

411. ДАВТАН СУРГАЛТЫН СУРГУУЛЬ

п) **АЖИЛЛУУЛАХ ЭРХ.** Ерөнхий захирал, Ерөнхий газрын бүх чиг үүргийг зохих ёсоор гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлээр Ерөнхий газрын ажилтнуудыг давтан сургах зорилгоор сургууль ажиллуулж болно. Түүнчлэн Ерөнхий захирал эдгээр сургуулийн сургалтад төрийн бусад албан хаагч, гадаад улсын албан хаагч, аэронавтикийн салбарын ажилтнуудыг суралцахыг зөвшөөрч болно.

СУРГАЛТЫН ЗАРДЛЫГ НӨХӨХ. Ерөнхий захирал, дээр дурдсан сургуулийн сургалтын зардлыг нөхөхийн тулд зохих төлбөр төлөхийг шаардаж болно.

412. ОСЛЫГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

Тайлбар: Ослын шалтгааныг тогтоохыг ИНЕГ-аас бусад төрийн эрх бүхий байгууллагад даалгасан байдаг. төрийн нэг байгууллагад ослын болзошгүй шалтгааныг тогтоох явдлыг аюулгүй ажиллагаа, биелэлтийг хамт төвлөрүүлэх нь зөрчилдөөн үргэлжлэн гарч болох нөхцөл болдог.

р) **ОСЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭХ.** Ерөнхий захирал агаарын хөлөг оролцсон ослын тухай мэдэгдэх, мэдээлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлан гаргана.

ОСЛЫГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЕРӨНХИЙ ЭРХ. Энэ хуулийн в)-д зааснаас бусад тохиолдолд Ерөнхий захирал дараахь эрх/бүрэн эрхтэй байна:

агаарын хөлөг оролцсон, монгол Улсын нутаг дэвсгэр дээр гарсан, мөн тус улсад бүртгэлтэй агаарын хөлөг оролцсон, бусад улсын нутаг дэвсгэрийн гадна гарсан ослыг болсон байдал, нөхцөл байдал, байж болох шалтгааныг тогтоохын тулд шинжлэн шалгах буюу гэрээ болон бусад байдлаар шинжлэн шалгуулах;

тус улсад бүртгэлтэй агаарын хөлөг оролцсон, бусад улсын нутаг дэвсгэр дээр гарсан ослыг шинжлэн шалгахад Монгол Улс, осол гарсан улсын хооронд байгуулсан гэрээ, конвенци, бусад тохиролцоонд нийцүүлэн оролцох.

ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ. Ерөнхий захирал, энэ зүйлийн үндсэн дээр зөвшөөрөгдсөн шинжлэн шалгах ажиллагааны дүгнэлтийг үндэслэн цаашид адил төстэй ослоос урьдчилан сэргийлнэ гэж үзсэн зөчлийг арилгах арга хэмжээ авна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙРЛАЛД ШИНЖЛЭН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ. Энэ зүйлийн бусад заалтыг үл харгалзан аль нэг гадаад улсын агаарын хөлөг оролцсон, Монгол Улс дахь зэвсэгт хүчний байрлалд гарсан ослыг шинжлэн шалгах ажиллагааг явуулах нь зэвсэгт хүчний үүрэг байна. Эн хэсэгт хэрэглэсэн утгаар “зэвсэгт хүчний байрлал” гэсэн нэр томъёо нь тус улсын нутаг дэвсгэр дэх Монгол Улсын буюу бусад улсын зэвсэгт хүчний мэдэлд байгаа нутаг дэвсгэрийг хэлнэ.

НОТЛОХ БАРИМТААР АШИГЛАХ. Аливаа осол буюу түүний шинжлэн шалгах ажиллагаанд холбогдолтой тайланг Ерөнхий захирал нотлох баримтаар хүлээж авах буюу эдгээр тайланд дурдсан асуудлаас үүссэн нэхэмжлэл, хохирол нөхөн төлүүлэх ажиллагаанд ашиглаж болохгүй.

413. НИСЛЭГИЙН СТАНДАРТЫН ГАЗАР

с) ГАЗАР БАЙГУУЛАХ. Ерөнхий захирал, агаарын хөлөг, нисэхийн ажилтнууд, нисэхийн тээвэрлэгч нарыг гэрчилгээжүүлэх Ерөнхий захирлын газраас үүргээ биелүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилго бүхий байгууллага байгуулж болно.

ТОНОГЛОЛ, АЖИЛТНУУД. Ерөнхий захирал нисэхийн аюулгүй ажиллагааны үүднээс Нислэгийн стандартын газарт чиг үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай тоноглол, ажилтнуудаар хангах эрхтэй.

Нислэгийн стандартын газрын бүрэлдхүүнд дараахь байгууллага байна:

Нислэгт тэнцэх чадварыг шалгах хэлтэс

Нислэгийн үйл ажиллагааны газар / Flight operations inspectorate/

Ажилтнуудад гэрчилгээ олгох газар.

414. БАТЛАН ЗӨВШӨӨРӨХ

т) Ерөнхий захирал гэрчилгээжүүлэх, үзлэг хийх үүргээ гүйцэтгэхдээ дараахь хязгаарлалттайгаар тодорхой арга хэмжээ авахгүйгээр бусад улсын иргэний нисэхийн удирдах газрын авсан арга хэмжээг хүчинтэйд тооцож болно:

1) нисэхийн ажилтан буюу нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хувьд нөгөө улс нь Чикагогийн конвенцийн оролцогч улс байх бөгөөд эдгээр гэрчилгээг олгох, одоогийн байдалд нийцсэн байлгах талаар уг конвенцийн дагуу үүргээ гүйцэтгэж байгаа байвал зохино.

Нисэхийн тээвэрлэгч нарт хамаарах арга хэмжээний хувьд Ерөнхий захирал үзэмжээрээ шийдвэрлэж туслах баримт бичиг шаардана. Хүчинтэйд тооцох нь өөр иргэний нисэхийн удирдах газрын авсан арга хэмжээнд үндэслэж байгаа бол Ерөнхий захирал, тухайн улс өөрийн Нисэхийн тээвэрлэгч нарыг гэрчилгээжүүлэх,

тэдний гэрчилгээг цаашид хүчинтэйд тооцох тухай Чикагогийн конвенцид заасан үүргээ биелүүлээгүй тухай мэдээ байхгүй байхыг хангана.

415. ҮЗЛЭГ ХИЙХЭЭР НЭВТРЭХ ЭРХ

у) Ерөнхий захирал агаарын хөлөгт түүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор эзэмшиж байгаа эсэхээс үл хамааран тухайн агаарын хөлөг нислэгт тэнцэх чадвартай бөгөөд энэ хууль, түүний дагуу гарсан журам, ОУИНБ-ын холбогдох хавсралтад нийцүүлэн эзэмших явдлыг хангах зорилгоор чөлөөтэй нэвтрэх эрхтэй.

Ерөнхий захирал Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор эзэмшиж байгаа агаарын хөлөгт түүнийг дэлхийд эзэмшиж байгаа эсэхээс үл хамааран тухайн агаарын хөлөг нислэгт тэнцэх чадвартай бөгөөд энэ хууль, холбогдох журам, шийдвэрт нийцүүлэн эзэмших явдлыг хангах зорилгоор чөлөөтэй нэвтрэх эрхтэй.

Ерөнхий захиралд Монголын нисэхийн тээвэрлэгч нараас аль ч үед аль ч газарт тухайн ажиллагааг энэ хууль, холбогдох журам, шийдвэрт нийцүүлэн явуулахыг хангах зорилгоор шалгалт, үзлэг хийхийг зөвшөөрнө.

416. НИСЛЭГИЙГ ХОРИГЛОХ ЭРХ

ф) Ерөнхий захирал дараахь нөхцөлд иргэний нисэхийн агаарын хөлгийн эзэмшигч буюу нисэхийн ажилтанд агаарын хөлгөөр нислэг үйлдүүлэхгүй байх шийдвэр өгөх эрхтэй:

агаарын хөлөг нислэгт тэнцэх чадваргүй;

нисэхийн ажилтан нислэг үйлдэх мэргэшилгүй эсхүл биеийн буюу оюун ухааны хувьд нислэг үйлдэх чадваргүй;

ажиллагаа нь газар дээрх хүмүүс буюу эд хөрөнгөд зайлуулах боломжгүй аюул учруулахаар байвал.

Ерөнхий захирал ийм агаарын хөлөг буюу нисэхийн ажилтныг саатуулахад шаардлагатай арга хэмжээ авна.

417. АГААРААР АЮУЛТАЙ ЗҮЙЛ ТЭЭВЭРЛЭХ ТАЛААРХ ЭРХ

Ерөнхий захирал Чикагогийн конвенцийн 18-р Хавсралт, ОУИНБ-ын Агаараар аюултай зүйлийг аюулгүй тээвэрлэх тухай техникийн зааврын биелэлтийг хянан шинжлэх, биелүүлэлтийг хангаж шаардлагатай бол Техникийн зааврыг зөрүүтэй хэрэглэж байгаа тухай Монгол Улсын нэрийн өмнөөс танилцуулна.

418. ОЛОН УЛСЫН ҮҮРЭГ

Ерөнхий захирал энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын засгийн газраас аливаа олон улсын гэрээ, конвенци, гадаадын улстай байгуулсан хүчин төгөлдөр гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нийцүүлэн ажиллана.

ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН УЛСЫН ХАРЬАЛАЛ, ӨМЧЛӨЛ

501. АГААРЫН ХӨЛГИЙН БҮРТГЭЛ

х) БҮРТГЭЛ БИЙ БОЛГОХ. Ерөнхий захирал Монгол Улсад агаарын хөлгийн улсын бүртгэлийн систем бий болгож хөтөлнө.

БҮРТГҮҮЛЭХИЙГ ШААРДАХ. Монгол Улсад буюу гадаад улсын хуулийн дагуу бүртгэгдээгүй иргэний агаарын хөлгийг тус улсад эзэмшсэнийг хууль бус гэж үзнэ.

БҮРТГҮҮЛЭХ ЭРХ. Агаарын хөлгийг зөвхөн гадаад улсад бүртгэгдээгүй бөгөөд Ерөнхий захирал өөрөөр зөвшөөрөөгүй бол дараахь этгээдийн өмчлөлд байгаа нөхцөлд бүртгүүлж болно:

Монгол Улсын иргэн;

Гишүүн бүр нь Монгол Улсын иргэн мөн тус улсын иргэн биш нөхөрлөл;

Монгол Улсын засгийн газар буюу түүний улс төрийн нэгж.

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ. Бүртгүүлэх эрх бүхий агаарын хөлгийн өмчлөгчөөс хүсэлт гаргаснаар түүнийг Ерөнхий захирал бүртгэж өмчлөгчид бүртгэлийн гэрчилгээ олгоно.

ӨРГӨДӨЛ. Гэрчилгээ олгохыг хүссэн өргөдлийг Ерөнхий захирлаас баталсан загвараар, түүний тогтоосон байдлаар бөглөж тогтоосон зүйлийг тусгасан байна.

ТҮР ЗОГСООХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ. Ерөнхий газраас олгосон аль ч гэрчилгээг Ерөнхий захирал олон нийтийн эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзсэн үндэслэлээр түр зогсоох буюу хүчингүй болгож болно.

УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ӨМЧЛӨЛИЙН НОТОЛГОО. Агаарын хөлөг энэ хуулийн дагуу бүртгүүлснээр Монгол Улсын харьяалалтай болно. Энэ зүйлийн дагуу олгосон бүртгэлийн гэрчилгээг агаарын хөлгийн өмчлөлийн талаар Монгол Улсын хуулийн дагуу явагдаж байгаа ажиллагаанд өмчлөлийн нотлох баримт гэж тооцохгүй.

502. АГААРЫН ХӨЛГИЙН ТАЛААР ЭДЛЭХ ЭРХИЙГ БҮРТГЭХ

ц) СИСТЕМ БАЙГУУЛАХ. Ерөнхий захирал үүгээр Монгол Улсад бүртгэгдсэн агаарын хөлгийн болон Монгол Улсад бүртгэгдсэн агаарын хөлөгт ашиглах агаарын хөлгийн аль ч хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл, эд анги өмчлөх болон түүний талаарх бусад эрхэд нөлөөлөх баримт бичгийг бүртгэх улсын системийг бий болгох эрхтэй.

Ерөнхий захирал бүртгэлийн систем бий болгосноос хойш түүнд бүртгэгдээгүй бол бүртгэгдсэн агаарын хөлөгт ашиглах агаарын хөлгийн аль ч хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл, эд анги өмчлөх болон түүний талаарх бусад эрхэд нөлөөлөх баримт бичиг холбогдох талуудын харилцаанаас бусад тохиолдолд хүчингүй байна.

ХОЛБОГДОХ ХУУЛИУД. Талууд өөрөөр заагаагүй бол дээр дурдсан байдлаар бүртгэгдсэн баримт бичгийн хүчинтэй байдлыг тус улсын хуулиар тодорхойлно.

Баримт бичгийг бүртгүүлэх шаардлагыг Ерөнхий захирлаас гаргасан журамд заасан байна.

ЗУРГААДУГААР ДЭД БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

601. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ЭРХ, ҮҮРЭГ

ш) АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭН ДЭМЖИХ. Ерөнхий захирал дараахь дүрмийг тогтоох, шаардлагатай үед шинэчлэх журмаар иргэний нисэх дахь иргэний агаарын хөлгийн аюулгүй ажилагааг дэмжинэ:

Чикагогийн конвенцийн хавсралтуудад заасан стандартуудыг биелүүлэх боломжит дүрэм, журам;

иргэний нисэхэд аюулгүй ажилагааг хангахад шаардлагатай гэж үзсэн бусад боломжит дүрэм, журам, наад захын жишиг.

НИСЭХИЙН ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫГ ЗОХИЦУУЛАХАД ХАРГАЛЗАН ҮЗЭХ ЗҮЙЛ. Ерөнхий захирал энэ хуулийн дагуу жишиг, дүрэм, журам тогтоох, гэрчилгээ олгохдоо нисэхийн тээвэрлэгч нараас үйл ажиллагаагаа олон нийтийн сонирхлын үүднээс аюулгүй ажилагааны дээд зэргийн түвшинд явуулах үүргийг харгалзан үзнэ.

602. НИСЭХИЙН АЖИЛТНЫ ГЭРЧИЛГЭЭ

э) НИСЭХИЙН АЖИЛТНУУДЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ЭРХ. Ерөнхий захирал, эзэмшигч нь агаарын хөлөгт ямар ажил албан тушаалд ажиллах эрхтэйг заасан нисэхийн ажилтны гэрчилгээ олгох эрхтэй.

ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ. Хүн бүр нисэхийн ажилтны гэрчилгээ олгохыг хүссэн өргөдлийг Ерөнхий захиралд гаргаж болно. Ерөнхий захирал, шалгасны эцэст тухайн этгээдийг өргөдөлд дурдсан ажлын үүргийг гүйцэтгэхэд зохих мэргэжилтэй бөгөөд биеийн эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзсэн бол гэрчилгээ олгоно. Ерөнхий захирал, тийнхүү шалгахгүйгээр ОУИНБ-ын гишүүн гадаад улсаас гэрчилгээ олгосныг өргөдөлд заасан ажлын үүргийг гүйцэтгэхэд зохих мэргэжилтэй бөгөөд биеийн эрүүл мэндийн хувьд тэнцэж байгаагийн нотолгоо гэж үзэж болно.

НӨХЦӨЛ. Гэрчилгээнд Ерөнхий захирлын иргэний нисэх дэх аюулгүй ажилагааг хангахад шаардлагатай гэж үзсэн нөхцөл, эрүүл мэндийн хувьд тэнцсэн эсэхийн дүгнэлтийг дурдаж болно.

ГАДААДЫН ИРГЭДЭД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ. Энэ хуулийн б-д зааснаас үл хамааран Ерөнхий захирал гадаадын иргэнд нисэхийн ажилтан гэрчилгээ олгохыг зохимжтой гэж үзсэн байдлаар хориглох буюу хязгаарлаж болно.

ГЭРЧИЛГЭЭНД ЗААВАЛ ЗОХИХ ЗҮЙЛҮҮД. Нисэхийн ажилтны гэрчилгээ бүрт дараахь зүйлийг заасан байна:

Ерөнхий захирлаас дугаарлаж бүртгэгдсэн байх;
нисэхийн ажилтанд олгосон давуу эрхийн зориулалт.

НӨХЦӨЛ. Ерөнхий захирал нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, тухайн агарын хөлгийг ашиглаж болох ажиллагаа болон аюулгүй ажиллагааны үүднээс шаардлагатай бусад нөхцөл, хязгаарлалт, мэдээллийг тусгасан байна. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүрийг Ерөнхий захирал бүртгэнэ.

НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ЗӨВШӨӨРӨЛ. Ерөнхий захирал өөрчлөлт оруулах зорилгоор нислэгт тэнцэх чадварын нэмэлт зөвшөөрөл олгох нөхцлийг тогтоож болно.

604. НИСЭХИЙН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ

ю) **ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ БАТЛАХ ЭРХ.** Ерөнхий захирал нисэхийн тээвэрлэгчийн гэрчилгээ олгох, гэрчилгээ олгосон ажиллагаанд мөрдвөл зохих аюулгүй ажиллагааны жишиг батлах эрхтэй.

ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ. Монгол Улсын иргэн хүн бүр Ерөнхий захиралд нисэхийн тээвэрлэгчийн гэрчилгээ олгохыг хүссэн өргөдөл аргаж болно. Ерөнхий захирал нарийвчлан шалгасны эцэст тухайн этгээдийг зохих тоног төхөөрөмжтэй бөгөөд энэ хууль, түүний дагуу гаргасан дүрэм, журам, жишигт нийцүүлэн аюулгүй ажиллагааны явуулах чадвартай болохоо харуулсан гэж үзсэн бол гэрчилгээ олгоно.

605. СУРГУУЛЬ, ЗӨВШӨӨРӨГДСӨН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД

я) **ШАЛГАЛТ, ЗЭРЭГЛЭЛ.** Ерөнхий захирал дараахийг шалгах, зэрэг олгох эрхтэй:
агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, туслах төхөөрөмжийг нисгэх, засварлах, засвар үйлчилгээ хийх, их засварын талаар сургалт явуулдаг иргэний сургуулиудыг сургалтын зохих ёсны байдал, тоног төхөөрөмж нь тохирсон, нислэгт тэнцэх чадвартай эсэх, багш нар нь мэдлэг мэргэжилтэй эсэх;

зөвшөөрөгдсөн засвар үйлчилгээний байгууллага, агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, туслах төхөөрөмжийн засвар, засвар үйлчилгээний газруудыг тоног төхөөрөмж, тоноглол, материал, засвар, их засварын арга зүй зохих ёсны бөгөөд тохирсон эсэх, ажил эрхэлсэн ажиллагчид, сургалт явуулагчид мэдлэг мэргэжилтэй эсэх.

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ЭРХ. Ерөнхий захирал дээр дурдсан төрлийн сургууль, зөвшөөрөгдсөн засвар үйлчилгээний байгууллагад гэрчилгээ олгох эрхтэй.

606. ӨРГӨДЛИЙН ЗАГВАР

Энэ хуулийн дагуу олгодог гэрчилгээ олгохыг хүссэн өргөдлийг Ерөнхий захирлаас баталсан загвараар гаргасан, түүнээс тогтоосон зүйлийг тусгасан байх бөгөөд Ерөнхий захирал тийнхүү шаардсан бол тангараг, баталгаатай байна.

607. АГААРЫН НАВИГАЦИЙН ТОНОГЛОЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НААД ЗАХЫН ЖИШИГ. Ерөнхий захирал Монгол Улсад байгаа агаарын навигацийн тоноглолын аюулгүй ажиллуулах наад захын жишгийг тогтоох, шаардлагын хэрээр үе үе өөрчлөх эрхтэй.

Энэ хэсэгт тодорхойлсон бөгөөд Ерөнхий захирлаас дүрмээр гэрчилгээжүүлэх шаардлагатай нисэх буудал ажиллуулахыг хүссэн хүн бүр Ерөнхий захиралд нисэх буудал ажиллуулах гэрчилгээ олгохыг хүссэн өргөдөл гаргаж болно. Ерөнхий захирал нарийвчлан шалгасны эцэст тухайн этгээдийг зохих тоног төхөөрөмжтэй бөгөөд энэ хууль, түүний дагуу гаргасан дүрэм, журам, жишигт нийцүүлэн аюулгүй явуулах чадвартай болохоо харуулсан гэж үзсэн бол уг этгээдэд нисэх буудал ажиллуулах гэрчилгээ олгоно. Нисэх буудал ажиллуулах гэрчилгээ бүрт комерийн агаарын тээвэрт аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай нөхцөл, хязгаарлалтыг заасан байна. Ерөнхий захирал олон нийтийн эрх ашигт нийцэхгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд эдгээр нөхцөл, хязгаарлалтад дараахь байдалд хамаарна:

аюулгүйн тоног төхөөрөмж, үүнд агаарын хөлөг буух, хөөрөх, газар дээр маневрлахад ашигладаг, нисэх буудлын аль ч хэсэгт түргэн хүрэх чадвартай гал унтраах болон авран туслах тоног төхөөрөмжийг ажиллуулах, түүнд засвар үйлчилгээ хийх;

Ерөнхий захирлын шаардлагатай гэж үзсэн үндсэн болон хоёрдогч runways ын байдал, засвар үйлчилгээ.

608. НИСЭХИЙН АЖИЛТНУУД, ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫН ҮҮРЭГ

аа) **ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫН ҮҮРЭГ.** Тээвэрлэгч бүр иргэний нисэхэд ашигладаг бүх тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээ, их засвар хийх буюу хийлгэх, эдгээр ажиллагааг энэ хууль, түүний дагуу гаргасан Ерөнхий захирлын дүрэм, журам, тушаалд нийцүүлэн явуулах явдлыг хангах үүрэгтэй.

НИСЭХИЙН АЖИЛТНУУДЫН ҮҮРЭГ. Нисэхийн ажилтны гэрчилгээ эзэмшигч бүр уг гэрчилгээний зөвшөөрөл, хязгаарлалт, энэ хууль, түүний дагуу гаргасан дүрэм, журам, тушаалыг биелүүлэх үүрэгтэй.

БУСАД ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ. Иргэний нисэхэд үүрэг гүйцэтгэж буй хүн бүр өөрийн үүрэгтэй холбогдсон энэ хуулийн заалт, түүний дагуу гаргасан дүрэм, журам, тушаалыг биелүүлэх үүрэгтэй.

АЮУЛТАЙ ЗҮЙЛ. Олон улсын нислэгээр Монгол Улсаас эхэлсэн буюу тус улсад ирсэн, түүнчлэн тус улсын доторхи нислэгт комерийн агаарын тээврээр илгээмж,

тээш, ачаа явуулж байгаа буюу хүлээж авч байгаа этгээд бүр Чикагогийн конвенцийн 18-р Хавсралт, ОУИНБ-ын Агаараар аюултай зүйл тээвэрлэх тухай техникийн зааврыг биелүүлэх үүрэгтэй.

609. ҮЗЛЭГ ХИЙХ ЭРХ

бб) ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ҮЗЛЭГ ХИЙХ ЭРХ. Ерөнхий захирал дараахь эрх, үүрэгтэй:

иргэний нисэхэд аль ч тээвэрлэгчийн ашиглаж байгаа агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл тухайн ашиглаж буй ажиллагаанд аюулгүй байдалтай хэрэглэж байгаа эсэхийг тогтооход шаардлагатай үзлэг хийх;

тээвэрлэгч бүрт эдгээр зүйлд үзлэг хийх тухайгаа мэдэгдэх.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГААГҮЙ АГААРЫН ХӨЛӨГ, ХӨДӨЛГҮҮР, СЭНС, ХЭРЭГСЭЛ. Ерөнхий захирал иргэний нисэхэд ашиглаж байгаа буюу ашиглах гэж байгаа аль нэг агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл аюулгүй ажиллагааг хангаагүй байдалтай болохыг тогтоосон бол энэ тухай тээвэрлэгчид мэдэгдэнэ. Тухайн агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгслийг Ерөнхий захирал аюулгүй ажиллуулах шаардлагыг хангасан гэж үзэх хүртэл иргэний нисэхэд аюул учруулахар ашиглаж болохгүй.

610. ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ ХИЙХ, ӨӨРЧЛӨХ, ТҮР ЗОГСООХ, ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ

вв) ДАВТАН ҮЗЛЭГ ХИЙХ, ШАЛГАХ. Ерөнхий захирал ямар нэгэн үндэслэлээр иргэний нисэхийн аль ч агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл, operator, сургууль, зөвшөөрөгдсөн засвар үйлчилгээний байгууллага буюу энэ хуулийн 602-р зүйлийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч нисэхийн ажилтанд давтан үзлэг, шалгалт хийж болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛААС АВАХ АРГА ХЭМЖЭЭ. Ерөнхий захирлаас хийсэн давтан үзлэг, шалгалтын дүнд иргэний нисэх, комерийн агаарын тээврийн аюулгүй ажиллагаа буюу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс шаардлагатай гэж үзвэл Ерөнхий захирал энэ хуулийн дагуу олгосон нислэгт тэнцэх чадварын, нисэхийн ажилтан, тээвэрлэгч, нисэх буудал, сургууль буюу зөвшөөрөгдсөн засвар үйлчилгээний байгууллагын гэрчилгээг бүхэлд нь буюу зарим хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийх, түр зогсоох буюу хүчингүйд тооцсон тушаал гаргаж болно.

ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИД МЭДЭГДЭХ, ХАРИУ ӨГӨХ БОЛОЛЦОО ОЛГОХ. Ерөнхий захирал дээр дурдсан аль ч гэрчилгээг бүхэлд нь буюу зарим хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийх, түр зогсоох буюу хүчингүйд тооцохын өмнө гэрчилгээ эзэмшигчид тийнхүү арга хэмжээ авахын үндэслэлийг мэдэгдэж, хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигчид түүнийг буруутгаж байгаа зүйлд болон гэрчилгээг нэмэлт, өөрчлөлт хийх, түр зогсоох буюу хүчингүйд тооцохгүй байх талаар тайлбар өгөх бололцоо олгоно.

ГОМДОЛ ГАРГАХ. Эхэ зүйлд зааснаар Ерөнхий захирлын тушаалаар гэрчилгээнд нь нэмэлт, өөрчлөлт хийсэн, түр зогсоосон буюу хүчингүйд тооцсон хүн бүр (байгууллага, албан тушаалтны нэр)-д гомдол гаргаж болох бөгөөд гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд Ерөнхий захирал оролцогч тал болно.

ГОМДОЛД ХОЛБОГДСОН ТУШААЛЫН ХҮЧИНТЭЙ БАЙДАЛ. Ерөнхий захирал зохих шүүхэд хойшлуулшгүй нөхцөл байдал байгаа бөгөөд иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны сонирхлын үүднээс тушаалыг нэн даруй хүчинтэй болгох шаардлагатай гэж мэдэгдээгүй бол гомдол гаргаснаар түүний хүчинтэй байдлыг түдгэлзүүлнэ. Ерөнхий захирал шүүхэд дээр дурдсанаар мэдэгдсэн бол гомдлыг шүүхээр хянан шийдвэрлэх хугацаанд тушаал хүчинтэй хэвээр байхаар тогтооно.

611. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

гг) Дараахь үйлдлийг хууль бус гэж үзнэ:

нислэгт тэнцэх чадварын хүчинтэй гэрчилгээгүй агаарын хөлгийг иргэний нисэхэд эзэмших;

аль нэг агаарын хөлөг, агаарын хөлөгт хэрэглэж байгаа буюу хэрэглэх гэж байгаа агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс буюу хэрэгсэлтэй холбоотойгоор нисэхийн ажилтны үүрэг гүйцэтгэх эрх олгосон гэрчилгээгүй буюу тухайн гэрчилгээний аль нэг нөхцөл, хязгаарлалтыг зөрчиж, эсхүл энэ хуулийн дагуу гаргасан аль нэг тушаал, дүрэм, журмыг зөрчиж үүрэг гүйцэтгэх;

иргэний нисэхэд ашиглаж байгаа аль нэг агаарын хөлөгтэй холбоотойгоор ажиллуулж байгаа ажлын үүргийг гүйцэтгэх эрх олгосон гэрчилгээгүй хүнийг нисэхийн ажилтнаар ажиллуулах;

нисэхийн тээвэрлэгчийн гэрчилгээгүйгээр буюу тийм гэрчилгээний аль нэг нөхцлийг зөрчиж нисэхийн тээвэрлэгч ажиллах;

иргэний нисэхэд агаарын хөлгийг энэ хуулийн дагуу гаргасан Ерөнхий захирлын аль нэг тушаал, дүрэм, журмыг зөрчиж ажиллуулах;

энэ хуулийн дагуу сургууль буюу зөвшөөрөгдсөн засвар үйлчилгээний байгууллагад олгосон гэрчилгээг эзэмшихдээ түүний аль нэг нөхцөл, хязгаарлалтыг зөрчих, энэ хуулийн дагуу гарсан, ийм гэрчилгээ эзэмшигчид хамаарах аль нэг тушаал, дүрэм, журмыг зөрчих.

ХАМААРАХГҮЙ БАЙХ. Ерөнхий захирал олон нийтийн сонирхолд нийцсэн гэж үзсэн нөхцлөөр гадаадын агаарын хөлөг, түүнд үүрэг гүйцэтгэж буй нисэхийн ажилтнуудыг энэ зүйлийн “а” хэсгийн заалтыг биелүүлэхээс чөлөөлж болно. Харин нислэгийн хөдөлгөөний дүрмийг биелүүлэх үүргээс чөлөөлж болохгүй.

ДОЛДУГААР ДЭД БҮЛЭГ. ШИЙТГЭЛ

701. ИРГЭНИЙ ШИЙТГЭЛ

дд) **ЕРӨНХИЙ ШИЙТГЭЛ.** Комерийн агаарын тээвэр буюу олон улсын агаарын тээвэрт үйл ажиллагаа явуулдагаас бусад этгээд энэ хууль буюу түүний дагуу гарсан аль нэг тушаал, дүрэм, журмыг зөрчсөн бол зөрчил бүрт (хэмжээг тус улсын мөнгөн тэмдэгтээр заана)-аас илүүгүй торгоно. Зөрчил үргэлжилсэн шинжтэй бол зөрчил гаргасан өдөр бүрийг бие даасан зөрчилд тооцно.

КОМЕРИЙН АГААРЫН ТЭЭВЭРТ ХАМААРАХ ШИЙТГЭЛ. Ерөнхий захирал аливаа иргэний шийтгэлийг үнэлэх, түүний талаар буулт хийх эрхтэй. Ерөнхий захирал шийтгэлийн хэмжээг тогтоохдоо гаргасан зөрчлийн шинж, ноцтой байдал, зөрчил гаргач этгээдийн гэм буруугийн хэр хэмжээ, урьд нь зөрчил гаргаж байсан эсэх, төлбөрийн чадвар, бизнесийн үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах боломжид хэрхэн нөлөөлөх болон бусад шаардлагатай байдлыг харгалзан үзнэ.

ИРГЭНИЙ ТОРГУУЛИЙН ХЭМЖЭЭГ ИНФЛЯЦИЙН ТҮВШИНД ТОХИРУУЛАХ. Ерөнхий захирал торгуулийн хэмжээг наад зах нь дөрвөн жил тутам инфляцийн түвшинд тохируулан шинэчлэн тогтооно. Ерөнхий захирал торгуулийн хэмжээг инфляцийн түвшинд тохируулан шинэчлэн тогтоохын өмнө санал болгосон өсгөх хэмжээг /Хууль тогтоох буюу гүйцэтгэх дээд байгууллага/-д батлуулахаар өргөн мэдүүлнэ. /Хууль тогтоох буюу гүйцэтгэх дээд байгууллага/-аас батлагдсан торгуулийн хэмжээг Ерөнхий захирал хэвлэн нийтэлнэ. Торгуулийн шинэчилсэн хэмжээг хэвлэн нийтэлснээс 30 хоногийн дараа хэвлэн нийтэлснээс хойш гаргасан зөрчилд оногдуулж болно.

АГААРЫН ХӨЛГИЙГ БАРЬЦААНД АВАХ. Иргэний агаарын хөлөг зөрчилд холбоотой бөгөөд түүний өмчлөгч буюу эзэмшигч зөрчил гаргасан бол уг агаарын хөлгийг шийтгэл оногдуулахаар барьцаанд авч болно.

АЮУЛТАЙ ЗҮЙЛ. Чикагогийн конвенцийн 18-р Хавсралт буюу ОУИНБ-ын Агаараар аюултай зүйл тээвэрлэх техникийн заавар-ыг зөрчиж аюултай зүйлийг тээвэрлэхээр өгсөн буюу хүлээн авсан этгээдийг энэ хуулийн 608-р зүйлийн “д” заалтыг зөрчсөн буруутай гэж үзэж дээр дурдсан Хавсралт, зааврын зөрчсөн заалт бүрт /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгоно.

702. ЭРҮҮГИЙН ШИЙТГЭЛ

ее) **ГЭРЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ.** Энэ хуулийн дагуу олгох аль нэг гэрчилгээг хуурамчаар буюу дууриалган үйлдсэн эсхүл тийнхүү үйлдэхийг завдсан этгээд, түүнчлэн агаарын хөлөгт түүний харьяалах буюу бүртгэгдсэн улсын таних тэмдгийг хуурамчаар буюу андуурагдахаар бичсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

АГААРЫН НАВИГАЦИД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ. Дараахь гэмт хэргийг үйлдсэн буруутай этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас

илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

Монгол Улсын агаарын навигацид хөндлөнгөөс оролцох зорилгоор тус улсын нутаг дэвсгэрийн дотор байршил, аргын хувьд энэ хуулийн дагуу батлагдсан жинхэнэ гэрэл буюу дохио, эсхүл нисэх буудал, агаарын навигацийн бусад тоноглолтой холбогдсон гэрэл, дохиотой андуурагдаж болох гэрэл, дохио буюу холбоо харуулсан, эсхүл Ерөнхий захирлаас зохих ёсоор анхааруулснаас хойш энэ үйлдлээ үргэлжлүүлсэн этгээд;

Дээр дурдсан жинхэнэ гэрэл, дохиог санаатайгаар зайлуулсан, унтраасан буюу хөндлөнгөөс оролцсон этгээд.

ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭХ. Энэ хуульд зааснаар Ерөнхий захиралд санаатайгаар мэдээлээгүй буюу мэдээлэхээс зайлсхийсэн, мөн Ерөнхий захирлын баталсан загвар, журмаар бүртгэл, мэдээг бүртгэх, хөтлөөгүй, тийнхүү хөтлөхөөс зайлсхийсэн, түүнчлэн бүртгэл, мэдээг засварласан, эсхүл бүртгэл, мэдээг хуурамчаар гаргасан нисэхийн тээвэрлэгч, түүний мэргэжилтэн, төлөөлөгч буюу ажилтныг хэрэг бүрт нь /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгож шийтгэнэ.

МЭДҮҮЛЭГ ӨГӨХӨӨС БУЮУ МАТЕРИАЛ ГАРГАЖ ӨГӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ. Ерөнхий захирлын дуудсанаар буюу хууль ёсны шаардлагын дагуу хүрэлцэн очиж мэдүүлэг өгөх, асуултад хариулах, эсхүл материал, бүртгэл, баримт бичиг гаргаж өгөх эрх бүхий боловч зайлсхийсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

АГААРЫН ХӨЛӨГ БУЛААХ. Агаарын хөлгийг булаан авсан буюу тийнхүү булаан авахыг завдсан этгээдийг хорьж шийтгэх, эсхүл агаарын хөлгийг булаан авсан буюу тийнхүү булаан авахыг завдсаны улмаас хүний амь хохирсон бол бүх насаар нь хорьж шийтгэнэ.

Агаарын хөлгийг булаан авахыг завдсан гэмт хэргийн үед агаарын хөлөг нислэг үйлдэж байсан эсэхээс үл хамааран агаарын хөлгийг булаан авах гэмт үйлдэл тус улсын хэргийн харьяалал дотор төгссөн бол агаарын хөлгийг булаан авахыг завдсан гэмт хэрэг тус улсын хэргийн харьяалалд хамарна.

НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ. Монгол Улсын хэргийн харьяаллын дотор агаарын хөлгийн бүхээгт байх үедээ нисэх багийн гишүүдийг үүргээ гүйцэтгэж байхад хөндлөнгөөс оролцсон эсхүл тийнхүү үүргээ гүйцэтгэх бололцоог бууруулсан этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгож шийтгэнэ.

Нисэх багийн гишүүдийг үүргээ гүйцэтгэж байхад хөндлөнгөөс оролцохдоо нисэх багийн гишүүн, үүнд үйлчлэгч рүү довтолсон, тэднийг доромжилсон, буюу айлган сүрдүүлсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл эсхүл ...-аас

илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино. Энэ хэсэгт дурдсан хэргийг үйлдэхдээ бусдын амь насыг хохироох буюу аюултай зэвсэг хэрэглэсэн этгээдийг ямар ч хугацаагаар хорих буюу насаар нь хорих ял шийтгэнэ.

ЭРҮҮГИЙН ЕРӨНХИЙ ЯЛ. Монгол Улсын шүүхийн харьяалал дотор байгаа агаарын хөлгийн бүхээгт байх үедээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйлдсэн бол тус улсын хуулийг зөрчсөн гэмт хэрэгт тооцогдох хэрэг үйлдсэний учир энэ зүйлд зааснаар шийтгэнэ.

ЗЭВСЭГ, ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ.

Комерийн агаарын тээврийн буюу тийнхүү ашиглах гэж байгаа агаарын хөлгийн бүхээгт байх үедээ нислэгийн үед өөрөө авч ашиглах боломжтой бусдын амь насыг хохироож болох буюу аюултай зэвсэг биедээ нуун авч явсан, эсхүл агаарын хөлгийн бүхээгт бөмбөг, бусад адил төстэй тэсэрч дэлбэрэх буюу гал авалцдаг төхөөрөмж байрлуулсан, байрлуулахыг завдсан этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

Хүний амины аюулгүй байдлыг үл харгалзан буюу түүнийг хэт болгоомжгүйгээр үл тоомсорлон энэ хэсгийн а-д дурдсан үйлдлийг хийсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

Энэ хэсгийн заалт ажил үүргийн хувьд зэвсэг авч явах эрх бүхий хууль хамгаалах байгууллагын ажилтнууд, түүнчлэн Ерөнхий захирлаас бусдын амь насыг хохироож болох буюу аюултай зэвсгийг комерийн агаарын тээвэрт авч явахыг зөвшөөрсөн, мөн зорчигчид нислэгийн үед авах боломжгүй тээшинд зэвсэг авч яваа хүнд хамаарахгүй.

АГААРЫН ХӨЛГИЙН АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ. Хүний амины аюулгүй байдлыг хэт болгоомжгүйгээр үл тоомсорлон Монгол Улсын хэргийн харьяалал дотор ашиглаж байгаа буюу тийнхүү ашиглах гэж байгаа агаарын хөлгийг аюулгүй ажиллуулахад хөндлөнгөөс санаатайгаар оролцсон этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

ХУДАЛ МЭДЭЭЛЭХ. Энэ хэсгийн “д “-“з “-д заасан гэмт хэрэг болох үйлдэл буюу тийм үйлдэл хийхээр завдсан тухай мэдсээр байж худал мэдээлэл өгсөн буюу өгүүлсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

Санатайгаар, гэмт зорилгоор буюу хүний амины аюулгүй байдлыг хэт болгоомжгүйгээр үл тоомсорлон энэ хэсгийн “д “-“з “-д заасан гэмт хэрэг болох

үйлдэл буюу тийм үйлдэл хийхээр завдсан тухай мэдсээр байж худал мэдээлэл өгсөн буюу өгүүлсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

ОСОЛ ТОХИОЛДСОН АГААРЫН ХӨЛГИЙН ХЭСГИЙГ САЛГАЖ АВАХ. Мэдсээр байж, зөвшөөрөлгүйгээр осол тохиолдсон агаарын хөлгийн аль нэг хэсгийг буюу ослын үед түүний бүхээгт байсан аль нэг эд хөрөнгийг салгаж авсан, нуун далдалсан буюу авч үлдсэн этгээдийг /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

АЮУЛТАЙ ЗҮЙЛ. Чикагогийн конвенцийн 18-р Хавсралт буюу ОУИНБ-ын Агаараар аюултай зүйл тээвэрлэх техникийн заавар-ыг зөрчиж аюултай зүйлийг тээвэрлэхээр өгсөн буюу хүлээн авсан этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж /тус улсын мөнгөн тэмдэгтээр хэмжээг заана/ -аас илүүгүй хэмжээгээр торгох буюу ...жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл ...-аас илүүгүй хэмжээгээр торгож ...жил хүртэл хугацаагаар хорино.

НАЙМДУГААР ДЭД БҮЛЭГ. АЖИЛЛАГАА

801. АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

жж) **АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ.** Ерөнхий захирал иргэний нисэхийн ажиллагааг хэвийн явуулах, шударга ёсыг тогтоох зорилгод нийцсэн байдлаар энэ хуулийн холбогдох зүйлд заасны дагуу ажиллагааг явуулна.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛДӨӨН. Ерөнхий газрын аль ч ажилтан Ерөнхий захирлын мөнгөний сонирхол бүхий хянан шийдвэрлэх буюу шалгах ажилаагаанд оролцож болохгүй.

Хүн бүр Ерөнхий захирал буюу түүнээс томилогдсон этгээд, эсхүл хуулийн зөвлөхийн өмнө биеэр мэдүүлэг өгч болно.

БАРИМТЖУУЛАХ, НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БАЙХ. Ерөнхий захирал үндэсний ашиг сонирхлын үүднээс нийтэд задрулахгүй байх шаардлагатай гэж үзээгүй бол Ерөнхий захирлын албан ёсны үйлдэл, түүний ажиллагаа гуравдагч талын хүсэлтээр нийтэд нээлттэй байна.

802. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛД ГОМДОЛ ГАРГАХ, ЕРӨНХИЙ ЗАХИРЛААС ЯВУУЛАХ ШАЛГАН ТОГТООХ АЖИЛЛАГАА.

зз) **ГОМДОЛ ГАРГАХ.** Хүн бүр энэ хууль буюу түүний дагуу тогтоосон аливаа шаардлагыг зөрчиж хэний ч болов хийсэн үйлдэл буюу эс үйлдлийн тухай Ерөнхий захиралд бичгээр гомдол гаргаж болно. Гомдолд холбогдсон этгээд түүнийг ёсоор болгоогүй бөгөөд гомдлын дагуу шалган тогтоох үндэслэлтэй бол Ерөнхий захирал гомдолд дурдсан асуудлыг шалган тогтоох үүрэгтэй. Ерөнхий захирал, гомдолд

шалган тогтоох ажиллагаа явуулах буюу арга хэмжээ авахыг шаардсан үйл баримтыг заагаагүй гэж үзсэн тохиолдол бүрт уг гомдлыг хянан шийдвэрлэхгүйгээр хэрэгсэхгүй болгож болно.

ШАЛГАН ТОГТООХ АЖИЛЛАГАА. Ерөнхий захирал өөрийн санаачилгаар хэдийд ч болов энэ хуулийн заалтаар өөрт нь харьяалуулсан, энэ талаар Ерөнхий захиралд буюу түүний өмнө гомдол гаргаж болох буюу энэ хуулийн аль нэг заалтын талаар үүсч болох асуудлын талаар шалган тогтоох ажиллагаа үүсгэх бүрэн эрхтэй. Ерөнхий захирал өөрийн санаачилгаар үүсгэсэн шалган тогтоох ажиллагааны талаар гомдлыг үндэслэн үүсгэсэн ажиллагааны нэгэн адил үргэлжлүүлэх бүрэн эрхтэй.

БИЕЛҮҮЛЭХИЙГ ШААРДСАН ТУШААЛ. Ерөнхий захирал гомдлоор үүсгэсэн шалган тогтоох ажиллагааны явцад өөрт нь харьяалагдах асуудлын талаар хэн нэгэн этгээдийг энэ хуулийн аль нэг заалт буюу түүний дагуу тогтоосон аль нэг шаардлагыг биелүүлээгүй болохын тогтоосон бол уг этгээдийг биелүүлэхийг шаардсан тушаал гаргана.

803. НОТЛОХ БАРИМТ.

лл) **ЕРӨНХИЙ ЗААЛТ.** Ерөнхий захирал Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаана ч хянан хэлэлцэх, зарлан дуудах хуудас үйлдэж гарын үсэг зурах, тангараг өргүүлэх, гэрчийг байцаах, нотлох баримт хүлээж авч болно.

ЗАРЛАН ДУУДАХ ХУУДАС. Энэ хуульд хэрэглэсэн утгаар Ерөнхий захирал гэрчийг зарлан дуудах хуудсаар хүрэлцэн ирж мэдүүлэг өгөх, шалгаж байгаа асуудалд холбогдолтой бүртгэл, баримт бичгийг гаргаж өгөхийг шаардах бүрэн эрхтэй.

ЗАРЛАН ДУУДАХ ХУУДСЫН ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЭХ. Хянан хэлэлцэх жиллагааг явуулахаар тогтоосон Моногл Улсын хаана ч гэрчийг хүрэлцэн ирэх, бүртгэл, баримт бичиг гаргаж өгөхийг шаардаж болно. Зарлан дуудах хуудасны шаардлагыг үл биелүүлсэн тохиолдолд Ерөнхий захирал буюу уг ажиллагааны аль нэг тал /эрх бүхий байгууллагын нэр/- аас гэрчийг ирэх, бүртгэл, баримт бичиг гаргаж өгөхийг шаардахад туслалцаа авч болно.

ТАНГАРАГТАЙГААР БИЧГЭЭР МЭДҮҮЛЭГ ӨГӨХ. Ерөнхий захирал өөрийн өмнө явагдаж байгаа ажиллагааны аль ч үед мэдүүлгийг тангарагтайгаар бичгээр авахаар шийдвэрлэж болно. Ийм мэдүүлгийг Ерөнхий захирлын томилсон, тангараг өргүүлэх эрх бүхий аль ч этгээдийн өмнө авч болно. Тангарагтайгаар бичгээр мэдүүлэг авах тухай санал болгосон тал буюу түүний хуулийн зөвлөхөөс нөгөө тал буюу түүний хуулийн зөвлөхөд ердийн боломжит хугацааны өмнө энэ тухай мэдүүлэг өгсөн байна. Хэнийг ч болов хүрэлцэн ирж тангарагтайгаар бичгээр мэдүүлэг өгөх, бүртгэл, баримт бичгийг гаргаж өгөхийг Ерөнхий захирлын өмнө гэрчийн мэдүүлэг өгөхтэй нэгэн адил шаардаж болно.

Тангарагтайгаар бичгээр мэдүүлэг өгч байгаа хүн бүрт анхааруулж үнэн зөв мэдүүлэхээ тангараглахыг шаардаж нарийвчлан байцаана. Мэдүүлгийг авч байгаа хүнээр буюу түүний зааврын дагуу бичүүлж өгсөн хүнээр гарын үсэг зуруулна. Мэдүүлгийг нэн даруй Ерөнхий захиралд өгнө.

Тангарагтайгаар бичгээр мэдүүлэг авах хүн гадаадад байгаа бол тухайн улсын хуулиар зөвшөөрсөн нөхцөлд Ерөнхий захирлаас томилогдсон буюу талуудын бичгээр харилцан тохирсон, эсхүл Ерөнхий захирлын хүсэлтээр харьяалсан шүүхийн албан бичгийн дагуу авч болно.

804. ГАРДУУЛАХ ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ТОМИЛОХ

кк) ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ТОМИЛОХ. Монгол Улс дахь нисэхийн тээвэрлэгч бүр болон тус улсад тээвэр эрхэлдэг гадаадын тээвэрлэгч бүр Ерөнхий захирлын гардуулвал зохих бүх мэдэгдэл, шийдвэр, шаардлагыг тухайн тээвэрлэгчийн энрийн өмнөөс хүлээж авах, энэ тухай Ерөнхий захиралд мэдэгдэж байх төлөөлөгчийг томилох үүрэгтэй. Томилолтыг өөрчилж болох бөгөөд энэ тухай мэдэгдэнэ.

ТӨЛӨӨЛӨГЧИД ГАРДУУЛАХ. Ерөнхий захирлын бүх мэдэгдэл, шийдвэр, шаардлагыг тээвэрлэгч бүр болон гадаадын тээвэрлэгч бүрт тэдгээрийн тус улс дахь энэ зорилгоор томилогдсон төлөөлөгчийн газрын албан байр буюу тус улс дахь оршин суугаа газрын хаягаар нь гардуулж болох бөгөөд үүнийг тухайн тээвэрлэгчид өөрт нь гардуулсантай адил үзнэ.

Томилогдсон төлөөлөгч гардуулсан зүйлийг хүлээж аваагүй буюу эзгүй байвал Ерөнхий захирлын гардуулвал зохих мэдэгдэл, шийдвэр, шаардлагыг Ерөнхий захирлын албан байранд зарлалын самбарт байрлуулна.

ГАРДУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ. Аливаа этгээдэд мэдэгдэл, шийдвэр, шаардлагыг эдгээрийг хүлээж авахаар томилогдсон түүний төлөөлөгчид биеэр гардуулах, эсхүл уг этгээд буюу түүний төлөөлөгчид баталгаат шуудангаар илгээнэ. Баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд өгсөн өдрийг гарддуулсан өдөрт тооцно.

805. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ГАЗАР. Энэ хуулийн дагуу аливаа хэргийг хянан шийдвэрлэх хурлыг ...-д /газрын нэр/ хийнэ.

806. ТУШААЛЫГ ШҮҮХ ХЯНАХ

Ерөнхий захирлын тушаал бүрийг сонирхогч этгээдээс гаргасан гомдлоор түүнийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ... хоногийн дотор ... / шүүхийн нэр/ шүүхээр хянан хэлэлцэнэ. Гомдлыг дээр дурдсан хугацаа өнгөрснөөс хойш гагцхүү хугацаа хэтрүүлсний үндэслэл бүхий шалтгаанаар шүүхийн зөвшөөрснөөр хүлээж авна.

ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА. Гомдлын нэг хувийг шүүхийн нарийн бичгийн дарга Ерөнхий захиралд явуулах бөгөөд Ерөнхий захирал түүнийг хүлээн авмагц гомдолд холбогдсон хэрэг/материалыг хэрэв байгаа бол шүүхэд гаргаж өгнө.

ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ. Гомдлыг Ерөнхий захиралд дамжуулсны дараа шүүх гомдолд холбогдсон тушаалыг батлах, өөрчлөх, бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгох, шаардлагатай бол Ерөнхий захирлын цаашид авах арга хэмжээг тогтоох онцгой эрхтэй.

ХЯНАХ АСУУДЛЫН ХЭМЖЭЭ ХЯЗГААР. Ерөнхий захирлаас үйл баримтыг тогтоосон байдлыг хангалттай нотлох баримтаар батлагдсан бол эцсийн гэж үзнэ. ...шүүх /шүүхийн нэр/ Ерөнхий захирлын тушаалыг эсэргүүцсэнийг түүнд мэдэгдээгүй бол хянан хэлэлцэхгүй.

807. ШҮҮХЭЭС АЛБАДАН БИЕЛҮҮЛЭХ.

кк)...ШҮҮХИЙН /ШҮҮХИЙН НЭР/ ХАРЬЯАЛАЛ. ...шүүх /шүүхийн нэр/ энэ хуулийн аль ч заалт, түүний дагуу гаргасан аливаа дүрэм, журам, шаардлага, тушаал, аливаа гэрчилгээний нөхцөл, хязгаарлалтыг албадан биелүүлэх эрхтэй.

ЭНЭ ХЭСГИЙГ АЛБАДАН БИЕЛҮҮЛЭХ ИРГЭНИЙ АЖИЛЛАГАА.

Хэн нэгэн этгээд энэ хуулийн аль нэг заалт, түүний дагуу гаргасан аливаа дүрэм, журам, шаардлага, тушаал, аливаа гэрчилгээний нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд Ерөнхий захирал түүнийг албадан биелүүлэх тухай ...шүүхэд /шүүхийн нэр/ өргөдөл гаргаж болно.

Ерөнхий захирлын хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий прокурор ...шүүхэд/шүүхийн нэр/ энэ хуулийн аль нэг заалт, түүний дагуу гаргасан аливаа дүрэм, журам, шаардлага, тушаал, аливаа гэрчилгээний нөхцөл, хязгаарлалтыг албадан биелүүлэх, зөрчил гаргасан этгээдэд шийтгэл оногдуулахад шаардлагатай ажиллагаа үүсгэж болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ОРОЛЦОХ. Ерөнхий прокурорын хүсэлтээр Ерөнхий захирал энэ хуулийн дагуу шүүхэд явагдаж байгаа аль ч ажиллагаанд оролцох эрхтэй.

808. ИРГЭНИЙ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ АЖИЛЛАГАА

нн) Энэ хуулийн дагуу оногдуулсан аливаа иргэний шийтгэлийг холбогдсон этгээдээр төлүүлэх, барьцаалах агаарын хөлгийн хувьд түүнд холбогдуулан ажиллагаа явуулах журмаар гүйцэтгэнэ.

АГААРЫН ХӨЛГИЙГ ХУРААН АВАХ. Барьцаалах агаарын хөлгийг хураан авч Ерөнхий захирлын мэдэлд хадгалуулж болно. Хураан авсан болон түүний үндэслэлийн тухай Ерөнхий прокурорт нэн даруй илтгэнэ. Ерөнхий прокурор Ерөнхий захирлаас хураан авсан агаарын хөлгийг барьцаалах шийдвэрийг биелүүлэх тухай нэн даруй шүүхийн ажиллагаа үүсгэх буюу тийнхүү үүсгэх боломжгүй байгааг Ерөнхий захиралд мэдэгдэнэ. Агаарын хөлгийг дараахь үндэслэлээр барьцаанаас чөлөөлнө:

торгууль буюу харилцан тохирсон хэмжээний мөнгийг төлсөн;
барьцаалах тухай шийдвэрийг шүүхээс албадан биелүүлэх журмаар хураан
авсан;

Ерөнхий прокуророос ажиллагаа үүсгэх боломжгүй байгаа тухай мэдэгдсэн;
торгууль буюу харилцан тохирсон мөнгийг төлсөн эсэхээс хамаарч барьцааг
Ерөнхий захирлаас тогтоосон хэмжээгээр өгсөн.

НИСЭХИЙН ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ТАЙЛБАР

Нисэхийн тээвэрлэгч нарыг эдийн засгийн хувьд зохицуулах үүргийг Иргэний нисэхийн ерөнхий газраас өөр төрийн байгууллагад хариуцуулсан байдаг. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт нь улсын нутаг дэвсгэрийн дотор иргэний нисэхийн аюулгүй болохтой зөрчилдөж болзошгүй, учир нь зохицуулагч эрх бүхий байгууллага эдийн засгийн сонирхлын үүднээс нисэхийн аюулгүй ажиллагааны хуулиар шаардсанаас доогуур түвшинг хүлээн зөвшөөрөхөд хүргэж магадгүй юм. Эдийн засгийн зохицуулалтыг аюулгүй ажиллагааны зохицуулалттай төрийн нэг байгууллагад нэгтгэх нь эдийн засгийн бололцоо, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа хоёрын хооронд байнгын хурцадмал байдал байж болзошгүй юм. Иймд эдийн засгийн зохицуулалтыг иргэний нисэхийн тухай хуулийн Есдүгээр дэд бүлэгт оруулсан боловч эдийн засгийн зохицуулалтын үүргийг иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны зохицуулалтын үүргээс салгаж төрийн хоёр өөр байгууллагад хариуцуулахыг зөвлөх байна.

Дор оруулсан эдийн засгийн зохицуулалт нь иргэний нисэхийн эдийн засгийн салбарыг зохицуулах эрх бүхий сайдаас Монголын нисэхийн тээвэрлэгч нарт комерийн агаарын тээвэрт олон нийтийн ая тух, хэрэгцээний гэрчилгээ олгох, мөн гадаадын нисэхийн тээвэрлэгч нарт Монгол Улсад комерийн агаарын тээвэр эрхлэх зөвшөөрөл олгох байдлаар эрх бүхий байгууллагуудын эрх, үүргийг хамаарч байгааг анхаарна уу.

ЕСДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ. НИСЭХИЙН ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

901. ОЛОН НИЙТИЙН АЯ ТУХ, ХЭРЭГЦЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ

pp) ГЭРЧИЛГЭЭ ЗААВАЛ АВСАН БАЙХ. Нисэхийн аль ч тээвэрлэгч комерийн агаарын тээвэр эрхлэхийг зөвшөөрөх эрх бүхий сайдаас олгосон хүчинтэй гэрчилгээгүйгээр комерийн агаарын тээвэр эрхэлж болохгүй.

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ. Гэрчилгээ олгохыг хүссэн өргөдлийг бичгээр, сайдын баталсан загвараар гаргасан байх бөгөөд түүний шаардсан мэдээллийг тусгасан байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ. Гэрчилгээ бүрт нисэхийн тээвэрлэгчид комерийн агаарын тээвэр эрхлэхийг зөвшөөрсөн гарах болон хэрэв байгаа бол завсрын цэгүүд, үзүүлэх үйлчилгээг заасан байна. Гэрчилгээгээр олгосон давуу эрхийн тодорхойлолт буюу түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд олон нийтийн сонирхлын үүднээс шаардлагатай боломжит нөхцөл, хязгаарлалтыг хавсаргасан байна.

Энэ зүйлийн дагуу олгосон хуваарьт буюу захиалгат нислэгийн журмаар олон улсын комерийн агаарын тээвэр эрхлэх гэрчилгээнд эцсийн болон завсрын цэгүүдийг зөвхөн сайдаас зохистой гэж үзсэн бол заах бөгөөд ердийн байдлаар зөвхөн баримтлах ерөнхий замыг тогтооно.

ГЭРЧИЛГЭЭГ ӨӨРЧЛӨХ, ТҮР ЗОГСООХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ. Сайд энэ хуулийн аль нэг заалт буюу түүний дагуу гаргасан аль нэг тушаал, дүрэм, журам, эсхүл уг гэрчилгээнд заасан аль нэг нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөний учир гэрчилгээг өөрчлөх, түр зогсоох, хүчингүй болгож болно. Хэн ч болов энэ хэсгийн а-д заасны дагуу гэрчилгээг өөрчлөх, түр зогсоох, хүчингүй болгосныг дэмжиж буюу эсэргүүцэж сайдад меморандум өгч болно.

ГЭРЧИЛГЭЭГ ШИЛЖҮҮЛЭХ. Сайд олон нийтийн сонирхолд нийцсэн гэж зөвшөөрснөөс бусад нөхцөлд гэрчилгээг бусдад шилжүүлж болохгүй.

ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ. Сайд зөвхөн даатгалын хураамж буюу сайдаас баталсан өөрөө даатгуулах даатгалын төлөвлөгөөний тухай тушаал, журмыг биелүүлсэн өргөдөл гаргагчид гэрчилгээ олгоно. Даатгалын хураамж буюу төлөвлөгөө нь даатгуулсан хэмжээнээс илүүгүй, гэрчилгээ бүхий агаарын хөлгийн ажиллагаа буюу засвар үйлчилгээний улмаас хүний амь насыг хохироосон, гэмтэл учирсан, эд хөрөнгө үрэгдсэн, түүнд хохирол учирсны хор уршгийг нөхөн төлөхөд хүрэлцээтэй байна. Нисэхийн тээвэрлэгч зөвхөн энэ заалтыг биелүүлсэн нөхцөлд түүний гэрчилгээ хүчинтэй хэвээр байна.

БАЙНГЫН ШААРДЛАГА. Энэ хуулийн дагуу гэрчилгээ буюу бусад эрх олгохыг хүссэн өргөдөл гаргагч бүр өргөдөлд дурдсан тээврийг эрхлэхэд эрүүл мэндийн хувьд тэнцсэн, тийм тээвэр эрхлэх хүсэлтэй бөгөөд чадвартай, энэ хууль, түүний

дагуу гаргасан аль нэг тушаал, дүрэм, журам, сайдын шаардлагыг биелүүлэх нь сайдаас зөвшөөрсөн тээврийг эрхлэхэд тийм нисэхийн тээвэрлэгч бүрт байнга хамаарах шаардлага болно. Нисэхийн тээвэрлэгч тээврийг эрхлэхэд эрүүл мэндийн хувьд тэнцсэн, тийм тээвэр эрхлэх хүсэлтэй бөгөөд чадвартай байх шаардлагыг зөрчсөн бол сайд тушаалаараа тийм гэрчилгээ буюу бусад эрхийг өөрчлөх, түр зогсоох, хүчингүй болгож болно.

902. ГАДАДЫН НИСЭХИЙН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

сс) ЗААВАЛ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙХ. Гадаадын нисэхийн аль ч тээвэрлэгч комерийн агаарын тээвэр эрхлэхийг зөвшөөрөх эрх бүхий сайдаас олгосон хүчинтэй зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад комерийн агаарын тээвэр эрхэлж болохгүй.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ. Сайд дараахь шаардлагыг хангасан гэж үзвэл зөвшөөрөл олгох эрхтэй:

өргөдөл гаргагч бүр өргөдөлд дурдсан тээврийг эрхлэхэд эрүүл мэндийн хувьд тэнцсэн, тийм тээвэр эрхлэх хүсэлтэй бөгөөд чадвартай, энэ хууль, түүний дагуу гаргасан бүх тушаал, дүрэм, журам, Ерөнхий захирлын шаардлагыг биелүүлнэ гэж зөвшөөрсөн;

өргөдөл гаргагч олон улсын комерийн агаарын тээвэр эрхлэх мэдлэг мэргэжилтэй, Монгол Улстай байгуулсан гэрээний дагуу түүнийг эрхлэхээр засгийн газраас томилогдсон, эсхүл уг тээвэрлэлт нь олон нийтийн сонирхолд нийцсэн байх.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ. Зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг бичгээр, сайдаас баталсан загвараар гаргасан байх бөгөөд түүний шаардсан мэдээллийг тусгасан байна.

ЗӨВШӨӨРЛИЙГ ӨӨРЧЛӨХ, ТҮР ЗОГСООХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ. Сайд энэ хуулийн аль нэг заалт буюу түүний дагуу гаргасан аль нэг тушаал, дүрэм, журам, эсхүл уг зөвшөөрөлд заасан аль нэг нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөний учир зөвшөөрлийг өөрчлөх, түр зогсоох, хүчингүй болгож болно. Хэн ч болов энэ хэсгийн а-д заасны дагуу зөвшөөрлийг энэ хэсгийн 'г' заалтын (1)-т зааснаар өөрчлөх, түр зогсоох, хүчингүй болгосныг дэмжиж буюу эсэргүүцэж сайдад меморандум өгч болно.

ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ. Сайд зөвхөн даатгалын хураамж буюу сайдаас баталсан өөрөө даатгуулах даатгалын төлөвлөгөөний тухай тушаал, журмыг биелүүлсэн өргөдөл гаргагчид зөвшөөрөл олгоно. Даатгалын хураамж буюу төлөвлөгөө нь даатгуулсан хэмжээнээс илүүгүй, зөвшөөрөл бүхий агаарын хөлгийн ажиллагаа буюу засвар үйлчилгээний улмаас хүний амь нас хохирсон, гэмтэл учирсан, эд хөрөнгө үрэгдсэн, түүнд хохирол учирсны хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцээтэй байна. Гадаадын нисэхийн тээвэрлэгч зөвхөн энэ заалтыг биелүүлсэн нөхцөлд түүний зөвшөөрөл хүчинтэй хэвээр байна.

